

# Орон бүхний пролетариат нар нэгдэгтүн!

# АНХ ДУГААР

# ТАВАН ЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.Д.Х-ын гүйцэтгэх захиргааны сонин

26 дахь жилдээ № 26 (2290) 1974 оны 4 дугаар сарын 1 ДАВАА

## НООЛУУР-ҮНЭТ МЯНДАС

Тус аймгийн нэгдлүүдэд МАА-н бүтээгдэхүүнээс орж байгаа жилийн мөнгөн орлогын 5,1, бүх төрлийн ноосноос ордог орлогын 25,0 хувь нь ноолуураас орж байна.

МАХН-ын Төв Хорооны IX бүгд хурлын шийдвэрийн дагуу ямааны ноолуурын үнийг улсаас 2 дахин нэмэгдүүлснээс манай аймгийн нэгдлүүдэд хагас сая төгрөгийн орлого шинээр нэмэгдсэн юм.

Ноолуур бэлтгэх улсын төлөвлөгөөг аймгийн хэмжээгээр 1971—1972 онуудад 101,3—103,7 хувиар биелүүлж байсан боловч 1973 онд 4,0 хувь буюу 1700 кг-аар тасалдуулжээ.

Өнгөрсөн онд ноолуурын төлөвлөгөөг Алтанбулаг, Баянжаргалан, Баянцогт, Бүрэн зэрэг 14 сум ямааны ноолуур самналтын ажлыг богино хугацаанд зохион байгуулалт сайтай явуулж биелүүлсэн байна.

Гэвч 1973 онд ямаа самналтын ажлыг хугацаанд нь олгийтой зохион байгуулаагүйгээс ноолуурын төлөвлөгөөг Баян-өнжүүл, Баяндэлгэр, Баянцагаан, Баянзүрх, Дэлгэрхаан, Лүн, Өндөрширээт сум 1,4—36,7 хувиар тасалдуулав.

1973 онд аймгийн хэмжээгээр тушаасан ноолуурыг 60, 80 дугаар чанарт хүргэсэн бол 285,0 мянган төгрөгийн нэмэгдэл орлогыг олох бололцоотой байсан юм. Энэ нь ХААН-үүдэд шинэ зураг төслөөр баригдаж байгаа хашаа 20 гаруйг барьж байгуулах хөрөнгөтэй тэнцэх юм. Гэтэл 1973 онд Алтанбулаг, Батсүмбэр, Баянзүрх, Баянцогт, Баянчандмань, Заамар, Лүн, Мөнгөнхорт, Эрдэнэ сумд бэлтгэсэн ноолуураа 29,1—66,4 хувийг 1, 2 дугаар чанартайгаар үйлдвэр баазал нийлүүлсэн нь аймгийн дунджаас 14,5—48,4 хувиар доогуур байна.

Энэ нь бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлж ашиг орлогыг нэмэгдүүлэхээр тавьж буй эдийн засгийн бодлогыг хангалтгүй биелүүлж байгаагийн баримт юм. Ямаа тарга хүч сайтай онд оруулж ноолуур авалтын ажлыг эртнээс сайн зохион байгуулалттай хугацаанд нь чанартай явуулснаас нэгжээс авах ноолуурын хэмжээг нэмэгдүүлж чанар сайтай бэлтгэж бодлогын тэргүүний ажиллагаатай ямаачид амьдрал нотлон үзүүлж байгаа юм.

Баянцагаан сумын ямаачин Жамбын Хүрэл 1969, 1970 онуудад хариуцсан ямаа нэг бүрээсээ 470 грамм ноолуур авч нэгжээс авах ноолуурыг улсын төлөвлөгөөгөөр өгөгдсөн нормоос 206 грамм аар илүү ашиглан, авсан ноолуураа 100 хувь 80, 60 дугаар чанараар улсад тушаажээ.

Ноолуурыг чанартай бэлтгэж төлөвлөгөөг хангадаг тэргүүний байгууллага малчдын туршлагаас үзэхэд ямаа самнах ажлыг хоёр үе болгон явуулдаг байна. Ямаа самналтын нэгдүгээр үеийг 3 дугаар сарын 20-ноос 4 дүгээр сарын 5-ны дотор явуулж, эхлээд самнах ямааг тусгайлан бэлтгэсэн дэвсгэр бүхий байранд оруулж өвчүү, хонго, гуя, гэдэс хээлийн ноолуурыг үсний налуу байдлыг дагуулан самнана.

Тэгэхдээ гурван номерын хамгийн жижиг самаар самнадаг. Гурван номерын самаар толгой, хөл, өвчүү, гэдэсний ноолуурыг, нэг номерын том самаар их биеийн ноолуурыг самнаж дараа нь бүх биеийг дахин хоёр номерын дунд самаар самнадаг байна.

Нэгдүгээр үеийн самналтаар 100 хувь 80 дугаар чанарын ноолуур гардаг ажээ.

Хоёрдугаар үед 4 дүгээр сарын 5—20 хүртлэх хугацаа орж энэ үед ямааны бүх биеийн ноолуурыг дахин нэг удаа бүрэн самнаан авч дуусгадаг болно.

Иймээс тэргүүний хүмүүсийн туршлагыг бүтээлчээр эзэмших, ямааны ноолуур самнагчдын семинар зөвлөлгөөн хийж туршлага судлах үзүүлэх сургууль зохиож, болзолт уралдаан зарлах, бригадлан самнал хийх, ноолуур авалтын чанартай байнгын хяналт тавьж ноолуурын төлөвлөгөөг чанар сайтай биелүүлэхэд ухуулга, сурталчилгаа, зохион байгуулалтын ажлыг чиглүүлэн ажиллах хэрэгтэй.

## Зөвлөлгөө өгөв

1973—1974 оны хичээлийн жилийн III улирлын амралтын хугацаанд Баяндэлгэрийн 8 жилийн дунд сургуулийн багш нар өөрийн сум-нэгдлийн 3 бригадал 7 хоногийн хугацаагаар явж малын зүй бусын хорогдлыг багасгах, төл бүрийг мал болгох, малын төл хүлээн авах талаар зөвлөмж зэрэг цаг үеийн ээлжит зорилттой холбогдсон сэдвээр 80 суурийн 648 хүнд ухуулга хийсний гадна 64 суурьт суурийн сургуулийг шалган үзэж багш нарт нь конспект хийх, хичээл заах аргын талаар зөвлөлгөө өгөв.

Б.БАЯРХҮҮ

## ЭВЛЭЛИЙН ШАГНАЛААР ШАГНАВ

Бүх ард түмний социалист уралдааны жил-1973 онд ажлын өндөр амжилт гаргасан манай аймгийн ажилчин, малчин, сэхээтэн 60 гаруй залуучуудыг МХЗЭ-ийн Төв Хорооны шагналуудаар шагнав. Уг шагналыг төв, хөдөөд гардуулах ажил зохиогдож байна.

«Шинэ амьдрал» нэгдлийн хоньчин Цогбаяр, Батсүмбэрийн САА-н ногоочин, улсын аварга Х.Ханд, Зуунмод хотын «Залуучуудын нэрэмжит» гуанзны тогооч, аймгийн аварга тогооч Г.Эрдэнэсүрэн, Баян-өнжүүл сумын хоньчин, БНМАУ-ын аварга малчин залуу О.Цэвэгмид нарыг эвлэлийн байгууллагын зардлаар ЗХУ-д жуулчуудлахаар Хүнсний комбинатын

ажилчин Г.Рина, барилгачин Б.Тэрбиш, Л.Бямбаа, Холбооны газрын стечин М.Жаргалмаа, Д.Дашдулам нарыг МХЗЭ-ийн Төв Хорооны «Тэргүүний ажилчин залуу» алтан медалиар, Алтанбулаг сумын хоньчин С.Должин, Сэр-гэлэн сумын саальчин Г.Цэцэнбилэг, Угтаалын САА-н хоньчин, илгээлтийн эзэн Ж.Борис, Т.Дуламсүрэн, Бүрэн сумын зоотехникч Б.Дашзэвэг, Баянжаргалан сумын үхэрчин Д.Дашпүрэв нарыг «Тэргүүний малчин залуу» алтан медалиар, Жаргаллантын САА-н ногоочин Ц.Сувдаа, Заамар сумын комбайнч Л.Гончиг нарын 20 шахам залууг «Тэргүүний тариаланч залуу» алтан медалиар шагналаа.

Аймгийн нэгдсэн болон нийцэн эх барих-бага эмч

Лүн сумын «Энхтуул» нэгдэл улсад нэгдүгээр байр эзэлж МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл, МҮЭ-ийн Төв Зөвлөлийн диглом, 40000 төгрөг, суудлын машин, Баянцогтын САА ургац хураалтаар улсад гуравдугаар байранд орж МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл, МҮЭ-ийн Төв Зөвлөлийн диглом, 40000 төгрөг, Ц.Сүрэнхорлоо даргатай 1 дүгээр тасаг «УАЗ» машин, Н.Лөгдөв даргатай 2 дугаар бригад мотоцикл хүлээн авав.

Улсын шагнал хүлээн авсан САА, ХААН-ийн хөдөлмөрдлийн цуглаан дээр Эрдэнэсүрэн, бригадын дарга Х.Цэндбаяр, Өндөрширээт сумын намын үүрийн нарийн бичгийн дарга Б.Доржсүрэн, аварга комбайнч Н.Болд нарын зэрэг хүмүүс уг хэлж 1974 оны тариа тариалт, хураалт малын хадлан тэжээл бэлтгэх ажил дээрээ өндөр амжилт гаргах үүрэг амлалт авцааа-лаа.

МАНай СУРВАЛЖЛАГЧ

Дуламсүрэн, ХААУ газрын ажилтан Д.Лхагва, холбоочин Нина нарын олон залууг МХЗЭ-ийн Төв Хорооны хүндэт үнэмлэх, баярын бичгээр шагнажээ.

Түүнчлэн залуу үеийг хүмүүжүүлэх ажилд идэвх зүтгэл гарган ажилласан зарим ажилтанг МХЗЭ-ийн тэргүүний ажилтан, залуу үеийг хүмүүжүүлэгч тэргүүний ажилтан тэмдгээр шагнасан юм.

Төв, хөдөөд болж байгаа шагнал гардуулах цуглаан дээр эвлэлийн байгууллагын шагнал хүлээн авч байгаа залуучууд бүх ард түмний уралдааны жил-1974 онд улам илүү амжилт гаргахад илэрхийлж нэмэлт үүрэг авч байна.

П.ЖАНЧИВ



Баяндэлгэр сум-нэгдлийн тэжээл-эмчилгээний цэгийн малчин Г.Баатарч яарч доройтсон малыг сайн тэжээж тэнхрүүлж байна. ЗУРАГ ДЭЭР: Г.Баатарч хонь тэжээж байгаа нь, Л.ГУНГААБУУ-ийн авсан гэрэл зураг



Аймгийн хэмжээгээр малын төл бойжуулах ажил ид явагдаж байна.

Манай аймагт бригад, фермүүдэд төл болон том малын хорогдолтой тэмцэх 46 штаб байгуулан ажиллаж гарсан төлөө 99,5 хувиар бойжуулж байгаагийн дотор Алтанбулаг, Баян, Баян-өнжүүл, Баянцагаан, Бүрэн, Лүн, Эрдэнэсэнт зэрэг сум нэгдлүүдийн төл бойжилт 100 хувьтай байна.

Баянцогтын САА-н хоньчин Бадарч, Жаргалантын

аргыг ор нэр болгон, төл, эх малд шаардагдах тэжээл, усны хүрэлцээ хангалтгүй, төлийн хайс хашаа, ус тэжээлийн онгоц дутагдалтай, хашаа лүзнэний засвар дулаалгагүй зэрэг дутагдал Баян-өнжүүл сумын Бараат, Бүрэн сумын Булангаа, Алтанбулаг сумын Жаргалант бригадууд Эрдэнэ, Баян-зүрх зэрэг сумдад оршиж байлаа.

Хариуцлагагүй ажиллагааны улмаас Жаргалантын САА-н Сандагжав 66,

## ТӨЛ БОЙЖИЛТЫН ЯВЦ

САА-н хоньчин Халзай, Эрдэнэсэнт сумын «Са-руул-амьдрал» нэгдлийн хоньчин Дэндэв зэрэг тэргүүний олон арван малчид малынхаа төлийг хөрвөжилтийн үе шатаар хорогдолгүй бойжуулж хамт олноо хошуучилж явна.

Гэтэл мал аж ахуйн материаллаг бааз байр, тэжээлийн хамгийн сайн нөхцөлтэй Заамар сумын «Заамар» нэгдэл, Жаргалантын САА гарсан төлийнхөө 2—3 хувь буюу 286—292 төл хорогдуулаад байгаа нь эдгээр сумдын удирдлага, МАА-н мэргэжилтэн, бригад, фермийн хариуцлагатан нараас төлийн бэлтгэл ажилд муу анхаарч малын арчилгаа, маллагаа, малчид, төлчдөд тавих хяналт шалгалтыг сулруулсантай холбоотой юм.

Үзлэг шалгалтаас үзэхэд олонхи сум хөрвийн

Дамбадаржаа 100, Баян-зүрх сумын Косорхаан 33, Заамар сумын Мэндбаар 27, Дамбаа 30 төл тус тус хорогдуулжээ.

Мөн Заамар нэгдлийн тэмээчин Мятав сумын төв дээр сууж тэмээгээ эзэнгүй тавьснаас 2 ботгыг осгоож үхүүлсэн зэрэг урагшгүй ажиллагаанаас болж аймгийн хэмжээгээр 903 төл хорогдоод байна.

Эдгээр дутагдалд дүгнэлт хийж, төл бойжуулах ажлын зохион байгуулалтыг улам сайжруулж, гарсан дутагдлыг газар авахуулахгүй засуулах, дутагдаж байгаа төлчинг сум, аймгийн төвөөс гаргах арга хэмжээ авах шаардлагатай байна.

Тэжээл дутагдсанаас хөрвийн аргыг хэрэглэхийн оронд хөрвө төлийг эхий нь дагуулан алс бэлчээрт явуулах, эсвэл хо-

тондоо үлдээж үс, ноос идүүлэх зэрэг зохисгүй байдал гаргадгийг анхаарч шаардагдах тэжээлийг суурь нэг бүрээр нарийн тооцоолж бригад, сууриудын хооронд зохицуулалт хийхийн хамт дутагдаж байгаа тэжээлийг аймгийн тэжээлийн конто-роос авч хангах хэрэгтэй.

Малын эмч мэргэжилтэн нарыг төл хорогдож байгаа суурь, бригадэд тогтвортой ажиллуулж хорогдлын шалтгааныг илрүүлэн тэр даруй нь зогсоох, малчид, төлчдийн ажиллагаанд тавих хяналт шалгалтыг шуурхай хүчтэй болговол зохино.

Гарсан төл бүрийг бүртгэж, хорогдсон төлийг тухай бүр нь илрүүлж, ихэр гарсан төлд гэрчилгээ олгож, хээл авсан нэг наст малыг суурь бүрээр судалж, арчилгаа, маллагааны сайн нөхцөлд байлгаж, гарсан төлийг 10 хоног тутам орлогод авч байвал зохино.

Нийт мал сүргийг хужир усаар тогтмол хангаж бэлчээрийг зөв хуваарилж, бэлчээх, услах цагийн хуваарийг нарийн баримтлан ажиллавал зохино.

Төллэлтийн үеийн суурийн ариун цэврийг чанд сахиж, хотны үс ноосыг тогтмол цэвэрлэж гаднаас ирж буй хүмүүсийг ариутгалын цэгээр дамжуулан нэвтрүүлдэг журамтай болох хэрэгтэй.

Төл бойжуулах ажлын эрч далайцыг улам чанаржуулж, малчид, төлчдийн дунд өрнүүлж байгаа социалист уралдааныг 7 хоног тутам дүнгэн шалгаруулж урамшуулах, тэргүүний арга туршлагыг дэмжин дэлгэрүүлж, сонин хэвлэлээр өргөн сурталчлах нь чухал байна.

Т. ЦЭВЭЭН

## ТӨЛИЙН ДУУ ЦАНГИНАН БАЙНА

(СУРВАЛЖЛАГА)

Бид Шинэ булгийн эхнээ бараантан харагдах хот айлын гадаа хүрвэ.

Хоньчин Жамбалжав гуай 30 гаруй жил малдагж 60 гаруй нас наслахдаа сүүлийн жилүүдэд хонин сүрэг маллаж өнөө жил САА-н 700 гаруй эр сувай хонь маллаж өнтэй тарган хаваржиж, илгээлтийн эзэн, туслах хоньчин Цэцэгмааг мал маллах арга ажиллагаанд сургаж малаа хорогдолгүй маллаж байгаагаа яриад бидэнд замчлав. Тэндээс аяны замаа үргэлжлүүлэхээр мордов.

Сууриар орж малчдын ажил байдалтай танилцан явахад урин хаврын сайрхан цаг ирж малчны хотонд төлийн дуу хөгжмийн эгшиг адил уянталан, сэргэлэн цовоо төл мал сул агсган сувд шиг ярайн үзэгдэнэ.

Хоньчин Гармаа 399 хононоос 400, Банзрагч 336 хононоос 345, Гунгааням 291 хононоос 300 хурга авч төлөө 100-гаас дээш хувьтай бойжуулж байв.

Бригадын даргын ярьсан нь

Манай бригад өнөө жил 222 унага, 3722 хурга бойжуулан авна.

Айраг 45000 литрийг

авч 2000 хонь сааж 21000 литр сүү авч тослогтой идээ боловсруулан аж ахуйдаа 20800 төгрөгийн цэвэр ашиг оруулах, 30 морь тэргэнд сургаж тэвэрт ашиглах, хонин суурийг зун, намрын улиралд нүүдлэн авто хөсгийг нүүдлийн тээврээс чөлөөлнө.

Эмнэг хангалгүй бригад болохоор 75 морно сургаж уналга эдэлгээнд оруулна гэж шуудхан хариулаад, адуучин Нэргүй, хоньчин Банзрагч, Лхамсүрэн, Гармаа гээд л амжилтаараа хошуучилж яваа сайчууд олон бай.

Манай бригад болсан 15 суурьтай.

Хонь төллүүлэх 9 суурьт 3009 хонь хургалж 3032 хурга, 12 гүүнээс 12 унага бүрэн мэнд бойжиж байна гэлээ.

Энэ нь тарга хүч сайн авахуулж, өвлийн бэлтгэлээ бүрэн хангасны үр юм гэж ажил төрлөө сэтгэл хангалуун танилцуулсан хүн бол тариаланчдын улсын зөвлөлгөөнд шалгарч «Алтан гадас» одонгоор энгэрээ малаасан, Батсүмбэрийн САА тэргүүний сайчуудын нэг адуу, хонь бригадын дарга Жадамба гуай юм.

Х. ДЭМЭД

## ДАШНЯМЫН СУУРЬ

Алтанбулаг сумын хоньчин Дашнямын суурь 472 хонь төллүүлэхээс 75 хувь нь төлөж гарсан төл нь 100 хувь бойжиж байна. Энэ суурийн хэд хэдэн чөл ихэрлэсний дотор 3 жил дараалан ихэрлэж 8 төл өгсөн халзан хониноос нь 3 ихэр хурга гарчээ.

Нөхөр Дашням 1974 онд 100 эх малаас 96 төл бойжуулахаар уралдаанд авсан үүргээ дагуулан биелүүлэхээр шамдан ажиллаж байна.

Ш. ДИНАМ

## МАЛЫГ УСААР ХАНГАХАД АНХААРЪЯ

Нам, засгаас мал сүргийг усаар хангахад онцгой анхаарч жил тутам олон арван уст цэгийг малын бэлчээрт гаргаж байна.

Төрөл бүрийн малын уух усны хэмжээ нь малын нас, арчилгаа, маллагаа, тэжээлийн шинж чанар, цаг агаарын байдал зэргээс хамааран харилцан адилгүй байдаг.

Өвөл хавар тэжээлийн чийг багассан үед малыг усаар сайн хангах нь авсан тарга хүчийг тогтоох, хээл хамгаалах, төл бүрэн бойжуулах үндэс болдог. Хөхүүл мал эр, сувай малаас гурав дахин их ус уудаг, нялх ба өсвөр малын бие махбод шингэн ихтэй байдаг бөгөөд тэдгээрийн бойжилт, өсөлтөнд ус онцгой үүрэгтэй.

Хаврын нөхцөлд бэлчээрийн ургамлын чийг ус багасаж энэ үед малын хээл томрох учир хөрсний ундаргатай худга харз булгийн усаар өдөрт

хоёроос доошгүй услахыг шаарддаг.

Усны эрдэс бодис нь малын тэжээлийн шингэцтэй сайжруулж өсөлт, хөгжилтийг хурдасгаад зогсохгүй биеийн эсэргүүцлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Төллөх болон төл малыг хүйтний улиралд худга харз уснаас услах нь муу бөгөөд ийм ус 1-4 градус хүйтэн тул үүнийг уусан мал өөрийн биед ашигтай болтол бүлээсгэхэд илүү хэмжээний дулаан зарцуулснаас биеийн зарим эрхтний ажиллагаанд муугаар нөлөөлөн хээл хаях, төл мал идсэн тэжээлээ боловсруулж чадахгүйд хүрнэ.

Иймээс эх малыг төллөсний дараа, төлийг 7-10 хоногоос эхлэн 7-12 градусын бүлээн усаар ундаж байвал малын тэжээл боловсруулах эрхтний үйл ажиллагааг сайжруулж, идсэн тэжээлийг

бүрэн боловсруулахад тусална.

Мал услах усны чанар нутгийн бүс бүрт өөр өөр байдаг.

Туршлагаас үзэхэд хээрийн бүсэнд малын уух усны бүлээн 2-5 градус усны эрдэс давсжилтын хуурай үлдэгдэл 1400 грамын литр байхад малын тарга хүч ашиг шим сайн байдаг байна.

Усны хурцдээ муутай газарт зөөврийн усаар төллөх болон төл малыг хангахдаа усан сан, ус халаах савыг ашиглан 20 градусас хэтрүүлэлгүй халааж өгнө.

Ус халаах савыг малын хашаанаас 25-30 метрийн зайд мал услахад тохиромжтой газрыг сонгон авч байрлуулж дэргэд нь модон онгоц тавина.

Онгоцонд ус үлдээхгүйн тулд усалж байгаа малын тоонд тохируулан усаа өгч байх нь чухал.

Малын тэжээл, уусан

ус хоёр нь тодорхой харьцаанд тохирч байж малын ашиг шимийг дээшлүүлэхэд үр ашгаа өгдөг байна.

Эхийн сүүний 89 хувь нь ус байдаг боловч уг ус нь сүүний доторхи бодистой нэгдмэл байдалтай байх тул цангаа гаргаж жинхэнэ усны үүргийг гүйцэтгэж үл чадна.

Иймээс нялх төлийг амьдралын эхний 7 хоног юмуу төлийг борог тэжээлд ормогц усалж сургавал зохино.

Ботгыг борог өвсөн тэжээлд «орох» (эхээс гараад хориод хоногны дараа) үед, унагыг сэрүүний улиралд өдөрт хоёр удаа, тургалыг 10-аад хоноод борог тэжээлд орж эхлэхэд, хурга, шигийг 10 хоногийн настайгаас нь эхлэн тэжээл усанд оруулан сургаж, бүлээн усаар тогтмол усалж байх хэрэгтэй.

Ус тэжээл хангалттай

байсан хурга, шигийг хөхүүл үедээ 25-30 кг жин нэмэгдэнэ.

Энэ нь эхээс ялгасны дараа онд бүрэн орох, ашиг шим арвинтай мал болох үндэс болдог.

Судалгаанаас үзэхэд нэг килограмм хуурай тэжээл тутамд дунджаар 2-6 литр ус ууж баймааж нь тэр тэжээл бүрэн шингэдэг бөгөөд усаар сайн хангагдсан малын эдийн засгийн үр ашиг яаж дээшилдгийг манай эрдэмтэдийн нотолсноос үзвэл, зөвхөн хонин сүргээр жишиж үзэхэд хонин ноос 10, сүү 30-35, тарга хүч 20 хувь нэмэгдэж, малын зүй бусын хорогдол эрс багасдаг байна.

Иймд уст цэгийг зөв байрлуулан, түүнийг хөврийн ажиллагаатай байлгаж малыг тогтмол услаж усалтын ажлыг бүртгэл тооцоотой болговол зохино.

Б. БАДАРЧ

## АРДЫН ХЯНАЛТЫН НУУР

## ХУВИЙН ХАРАА

МЭ (32)

Аймгийн ардын хянан шалгах хороо Баянжаргалан сумын «Баян эрхтий» бригадын эмчилгээ тэжээлийн цэгийн ажиллагаанд саяхан шалгалт хийлээ.

Тус цэг нь улсын төлөвлөгөөгөөр 1973 онд байгуулагдаж 5 дугаар сард машин тээвэр, жийг олгосон байна.

Гэтэл «Шинэ амьдрал» нэгдэл цэгийн барилга байгууламжийг 10 дугаар сард эхлэн барьсан боловч бүрэн дуусгаагүй саравч нь онгорхой поорхой, хуурай хэвтэр бууцаар хангалтгүй байв.

Өнгөрсөн оны 8 дугаар сараас эхлэн хүлээж авсан малын 45,9 хувь нь

## АЙМГИЙН АРДЫН ХЯНАН ШАЛГАХ ХОРООНД

үхэж хорогдсон, шалгалт хийх үед 60 гаруй мал эргүү өвчтэй байхад мал эмнэлгээс ямар нэг арга хэмжээ аваагүй байна.

Цэг дээр цуглуулсан малын олонх нь халдварт өвчтэй байв.

Малын тэжээлд зориулсан өвсний чанар муу, мал

тэжээх жорыг мөрдөж ажилладаггүй, үхэж хорогдсон малын түүхий эдийг ашиглалгүй үрэгдүүлсэн, цэгийн машиныг зориулалтын бус болон хувийн хэрэгцээнд жоооч Маналсүрэн хэрэг-

Шалгалтын дүнг аймгийн АХШ-ны хурлаар хэлэлцээд дээрхи дутагдал нь удирдах байгууллагын шийдвэр үүрэг даалгаврыг биелүүлэх ажилд муу анхаарч, зохиосон ажлынхаа гүйцэтгэлд тавих

Батаа нарын хариуцлагатай ажиллагаанаас шалтгаалсан байна гэж үзэв.

Аймгийн АХШ-ны хурлаас н. Ишжамцыг донгодж, Очир-бат, Батаа нарт захиргааны арга хэмжээ мөнгөн төлөөс оногдуулж, авто машиныг хувийн хэрэгцээнд ашигласан жоооч Маналсүрэнд 600 төгрөгийн төлбөр ноогдуулав.

Эмчилгээ-тэжээлийн цэгийг бүрэн ажилд оруулж, малын эмчилгээ тэжээлд эрчилгааг сайжруулан зүй бусын хорогдлыг эрс багасгахыг «Шинэ амьдрал» нэгдлийн зөвлөсүмн 300 мал эмнэлгийн тасагт хатуу анхаарууллаа.

## Цагийн сайханд тайвширч болохгүй

Малын зүй бус хорогдолтой тэмцэх ажил эрхлэсэн улсын онцгой комиссын групп, Аймгийн АХШ хороо хамтран Сэргэлэн, Баянзүрх, Эрдэнэ, Баяндэлгэр сумын МАА-н 10 бригад, 127 суурийн 627 малчидтай уулзаж ажил байдалтай танилцаж, зөвлөлтөө өгсний гадна 5 эмчилгээ тэжээлийн цэгийн ажлыг шалгаж.

Шалгалтын дүнгээс үзэхэд дээрхи сумдад малын зүй бусын хорогдолтой тэмцэх онцгой комисс байгуулан төлөвлөгөө график, ажлын хуваарь гаргасан боловч бригад, суурь, штабуудын ажил жигд биш байна.

Эдгээр сумдад 140—280 том мал зүй бусаар хорогдож, Баянжаргалан, Баян сумдад 182—238 мал хээл хажээ.

Баянжаргалан сумын «Баян эрхтий» бригадын зарим хариуцлагатнууд хичнээн өвөлжөө, хаваржаа, худалтай болох, төлөө ямар аргаар бойжуулахаа мэдэхгүй байв.

Дээрхи сумдад байгаа нийтлэг дутагдал нь сууриуд хаваржаандаа бүрэн бууж түүнээ засаагүй өвс хужир татаагүй, худал булаг шандаа засаагүй байна. Мөн малын хүйдэс овоолж, өвөлжөө бууцыг

цэвэрлэх тэжээлийн орлого зарлагын тооцоо хөтлөх ажил биелэхгүй эмчилгээ тэжээлийн цэг шаардлагын хэмжээнд хүртэл ажиллаагүй байна.

Сэргэлэн сумын эмчилгээ-тэжээлийн цэгийн хашаа онгорхой, тэжээл хужир төлийн пүнгүй хэд хичнээн мал хүлээн авч эмчилсэн тооцоо судалгаа, мал эмчилгээний журмал, зарцуулсан эмийн тооцоогүй байгаа ба цэгийн машиныг бригад сууриар тодорхой хуваариар явуулахгүй байна.

Баянзүрх, Баяндэлгэр сумдын эмчилгээ тэжээлийн цэг мөн л тохижиж олигтой ажиллаж чадаагүй байна.

Баяндэлгэр сумын «Байдла» бригадын дарга Нацагийнтай айл байгаа Д. Долгорынхоос 24, Батсүхийнхээс 2 хонь ямаа хорогдсон байхад арга хэмжээ аваагүй байна.

Иймд цагийн аятайд тайвширч, малын хорогдлыг таслан зогсоох талаар шуурхай арга хэмжээ авахгүй цаг алдаж байгаадаа дүгнэлт хийж хяналт шалгалтын ажлыг сайжруулах нь эдгээр сумдын хойшлуулгүй зорилт болж байна.

Аймгийн АХШ хорооны хянан шалгагч Д.РЭГЗЭН

## ЗХУ-ЫН АХШ БАЙГУУЛЛАГЫН ТҮРШЛАГААС

ЗХУ-д 9 сая гаруй идэвхтнийг эгнээндээ багтаасан ардын хяналтын байгууллага ажилладаг.

ЗХУ-д ардын хяналтын олон түмний доод шатны байгууллага болох заводын группийн ажлын туршлагаас авч үзвэл үйлдвэрлэл болон үйлдвэрлэлийн хугацаатай ажлаа нягт холбон явуулдаг байна.

Тухайлбал Липецкийн төмөрлөгийн заводын ардын хянах групп ажлаа төлөвлөхдөө үйлдвэрлэлийн үндсэн фондын ашиглалт, түлш түүхий эд материал, цахилгаан эрчим хүчний зарцуулалт, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, түүний өөрийн өртгийг хямдруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд шинэ техник нэвтрүүлэн, механикжуулах, автоматчлах, тэргүүн туршлага нэвтрүүлэх, хөдөлмөрдлийн ажлын нөхцөл ахуйн үйлчилгээг сайжруулах, удирдлагын аппаратыг төгөлдөржүүлэхэд чиглүүлдэг ажээ.

Төлөвлөсөн ажлаа хэрэгжүүлэхийн тулд төрөл

бүрийн өндөр мэргэжил бүхий хүмүүсийг татан оролцуулж ажилладаг нь үр дүнгээ өгсөн байна.

Энэ заводын ардын хянах групп нь үйлдвэрлэлээс гарч байгаа бүтээгдэхүүний чанарт гол анхаарлаа чиглүүлэн ажилладаг.

Ардын хянан шалгагчдын өөрсдийн санал, дүгнэлтийг үйлдвэрлэлийн удирдлага, намын байгууллагад мэдээлдэг байна.

Тэдний саналыг үндэслэн захиргаа нь тэргүүний хүмүүсийг шагнаж, урамшуулах ажилладаг хайнга хандагсдыг шийтгэх арга хэмжээ авдаг юм.

Хэрэв авсан арга хэмжээ ардын хянан шалгалтад хангалттай бус санагдвал, тэд район, хот, мужийн ардын хянах хороод хүртэл саналдаа бириж, тэдгээр нь уг асуудлыг зөвлөлтийн болон намын зохих дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлдэг байна.

## ГАРАА САЙН БАЙНА

Дэлгэрхаан сумын «Залуучуудын хөгжил» нэгдлийн малчид, малын зүй бус хорогдлыг багасгахын тулд энэ онд том малын зүй бусын хорогдлыг 55, хээл хаялт сувайралтыг 41,2, төлийн хорогдлыг 40 хувиар багасгах зорилттой ажиллаж байна. Тус сумын намын үүр, АДХ-ын гүйцэтгэх захиргаа, нэгдлийн зөвлөл оны эхэнд нийт малчдаар тодорхой үүрэг амлалт авахуулж гишүүн бүрийн жилдээ хийж гүйцэтгэх ажлыг өгч, намын гишүүд, депутатуудад онцгой даалгаврыг хамт олны нь өмнө гардуулжээ.

Ингэж ажилласнаар «Давст» бригадын хоньчин аймгийн АХ-ын депутат Дагвадорж, хоньчин Б. Дорж, Лувсанцэрэн, «Тарган» бригадын хоньчин Довчин, Адъяа нарын олон малчид малын зүй бус хорогдол гаргаагүйгээс гадна төлөө 100—101 хувиар бойжуулж байна.

П. ШАТАРБААТАР

## ҮЗЛЭГ ШАЛГАЛТЫН МӨРӨӨР

## ҮЗЛЭГЭЭР ЮУ ИЛРЭВ

Дэлгэрхаан сумын АХШ групп, ХБА-тай хамтран эд хариуцагч найман нэгж дээр бараа материал мөнгөн кассанд гэнэтийн шалгалт хийхэд агент Цогзолноров, Гаваа, Жанчин нар нийтдээ 14 мянга гаруй төгрөг дутаасан байв.

Эдгээр нэгжүүд нэгдүгээр улирлын бараа, ном борлуулалт, хөлдүү түүхий эдийн төлөвлөгөөний 12 нэр төрлийг 100—360 хувиар биелүүлжээ.

Гэвч агент Гаваа, Цогзолноров, Чойжамц нар бараа, ном борлуулах төлөвлөгөөг 76—83 хувиар, хөлдүү түүхий эдийн 35 нэр төрлийг биелүүлэхээс 31-

ийг тасалсан байв.

Шалгалтын дүнгээс үзэхэд дээрхи агентууд барааг бусдад зээл өгч, нилээд хэсгийг нь хувьдаа ашиглажээ.

Шалгалтын дүнг АХШ-гийн товчоо, ХБА-гийн ажилчдын зөвлөлгөөнөөр хэлэлцэж, дутагдсан мөнгийг 3 дугаар сарын 15-ны дотор төлж, улсыг хохирулгүй болгох, бараа, ном, хөлдүү түүхий эд, нохойн арьс, эсэгууль, малын яс, техникний тос зэрэг 16 нэр төрлийн зүйлийн төлөвлөгөөг биелүүлэхийг шаардсан АХШ-гийн шаардах хуудсыг тэдгээр агентууд, ХБА-д өгөв.

Ш. ЧУЛТЭМДАРЖАА

Аймгийн АХШ хорооноос 1973 онд явуулсан шалгалтын мөрөөр Баяндэлгэр сумын ХБА-ийн хамт олон тодорхой ажил зохиожээ.

Юуны урьд шалгалтын дүнг бүх ажилчдын зөвлөлгөөнөөр хэлэлцэж өр авлага барагдуулах комисс байгуулан ажиллажээ.

ХБА-ийн дотоод ажил, бичиг хэргийн соёлжилт, боловсруулалт, түүний хадгалалт хамгаалалтыг сайжруулах талаар гаргасан БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 276 дугаар тогтоол бичиг хэргийн зааврын биелэлтэнд ангийн даргын үзлэг явуулж нийт ажилтан нарт бичиг

хэргийн заавраар 2 цагийн семинар өгч дотоод ажлыг сайжруулах, данс бүртгэл үнэт цаасны хадгалалтыг сайжруулан тусгай хүнд хариуцуулан өгч, цоож бүхий савтай болгожээ.

Бичиг хэргийг зааврын дагуу хийж түүнд байнгын хяналт тавьж байхын тулд орон тооны бус бичиг хэргийн эрхлэгчийг томилон ажиллуулж байна.

Өлзий, Жамсран, Аюуш, Дагва-очир, Дашзэвэг нарын 16 хүнээс 21 мянган төгрөгийн өр төлбөрийг хураан барагдуулжээ.

Зарим эд хариуцагч нарын тооцоог дахин шалгаж, дутагдлын талаар то-

дорхой акт бичиж, зээлээр олгож бэлэн мөнгөнд тооцож явсан мөнгийг хураан авах ажил зохиожээ.

Мөн агент, худалдагч нарын тооцоог сараар, няравуудын тооцоог улирлаар боддог болж шалгалтын үед үнэнч биш байдал гаргаж, хариуцлага алдсан ХБА-ийн зарим ажилтан нарт ангийн захиргаанаас арга хэмжээ авч, хувийн хэрэгт нь төмдөлгөв.

Ажилчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэхийн тулд тэднийг хуулийн дугуйлан ахуйн соёлын сургуульд хамруулсны гадна оройн сургуульд 5 хүн суралцаж байна.

Б. БАЛАНСҮРЭН

## Сурвалжлах идэвхтнүүд мэдээлж байна

Төл бойжилт, тариалалт урган хураалт, өмс хадлан, сүү сааз бэлтгэлийн үеэр манай сонинны сурвалжлах идэвхтнүүд утас дахилгаан шуудангаар цаг үеэ тусгасан чухал мэдээ материал олныг ирүүлдэг юм.

## ТӨЛ БОЙЖУУЛАХ ТӨВ ШТАБ

Борнуур сум—САА-н Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргааны хавсарсан хурлаар төл бойжуулах төв штабыг 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж штабын даргаар малын их эмч Цэрэндагвыг томилон ажиллуулж байна.

Төл бойжуулах штаб нь ажлын тусгай төлөвлөгөө хийж, түүнийгээр мөрдлөг болгон ажиллаж байна.

Энэ штаб юуны өмнө эмчилгээний цэгийг тохижуулж, өвчтэй малыг ядарч доройтохоос өмнө авчирч эмчлэн тэжээх ажил хийдэг болсон байна.

Мал төлөлтийн үеэр бригад, суурь бүр дээр дутагдаж байгаа зүйлийг нь яаралтай хангах арга хэмжээ авч байна.

Долоо хоног бүр комиссын хурал хийж, төл бойжилтын явцыг хэлэлцээд цаашид хийх ажлаа зөвлөдөг.

Мөн бригад, сууриудын төл бойжуулалтыг цуваагаар байр эзлүүлэн урамшуулдаг юм.

Одоогоор төл бойжуулалтын талаар хоньчин Юрэн, саалийн 5 дугаар бригад тэргүүлж явна.

Энэ бүхний үр дүнд том мал зүй бусаар хоргдох нь багасаж төл сайн бойжиж байна.

## СУРАГЧДЫН ТУСЛАЛЦАА

Борнуур сум САА-н дунд сургуулийн 120 гаруй сурагчид 3 дугаар улирлын амралтаараа мал төлөлтийн ажилд туслацгааж 14 хоногт 574 төл бойжуулж, 2200 литр сүү сааж, 80 гаруй мал тэжээж, 120 кубметр хотны бууц, малын хэвтэр цэвэрлэв.

Багш Ч. РАГЧАА

## ЦЭВЭРЛЭГЧДИЙН СЕМИНАР

Аймгийн УЭ-ийн зөвлөл, АЦХС-ын станцаас Зуунмод хотод аймгийн төвийн албан үйлдвэрийн газруудын аж ахуйн эрхлэгч, цэвэрлэгч нарын семинар, үзүүлэх сургууль зохиов.

Энэ сургууль семинарт 100 гаруй хүн оролцож цэвэрлэгээний байдлын талаар АЦХС-ын станцын эрүүл ахуйн их эмч Хоролсүрэн товч мэдээлэл хийж, цэвэрлэгээний эрүүл ахуйн үндэс, цэвэрлэх аргачлал, цэвэрлэгчийн хөдөлмөр хамгааллын талаар мэргэжлийн хүмүүс хичээл заав.

Дараа нь Зуунмод хотын II гуанз, I дүгээр яслд цэвэрлэгээний талаар үзүүлэх сургууль хийж, ХБУГ, I дүгээр яслд, Сүрьеэ диспансерт соёлч байгууллагын гэрчилгээ олгож, зарим цэвэрлэгч нарыг шагнав.

Д. АЮУРЗАНА

## ЗӨВЛӨЛГӨӨН

Зуунмод хотын худалдаа бэлтгэлийн трестийн ажилчин албан хаагчдын зөвлөлдөөнөөр социалист уралдаанд түрүүлэгсэдийн чуулга уулзалтын уриалга «Худалдаа бэлтгэлийн байгууллагуудын тэргүүний ажилчдын зөвлөдгөөн хийлгэх тухай» аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргаа, УЭ-ийн зөвлөлийн тогтоолыг биелүүлэх асуудал хэлэлцэв.

Чуулга уулзалтанд оролцсон тэргүүний худалдагч Б. Дашзэвэг зөвлөдгөөний шийдвэрийн тухай тодорхой ярих.

Их дэлгүүрийн I дүгээр заалны хамт олныг төлөөлж худалдагч Долгор аймгийн бүх худалдагч нарыг уралдаанд уриалж дулааны улиралд цуваа графиктар ажиллах, хөдөлмөрдөөс урьдчилан захиалга хүлээн авах тасаг ажиллуулах, соёлч үйлчилгээтэй тасгийн болзлыг хангаж жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг I сарын өмнө биелүүлэхээр үүрэг амлалт авав.

Г. ГАЛЯ

## ДӨРӨВДҮГЭЭР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Дөрөвдүгээр сарын дундаж агаарын температур 2—4 градус дулаан, хөвийн хэмжээнээс 1,5 аас 2 градус дулаан байна.

Сарын шинэдээр хүйтэвтэр, шөндөө 9—14 градус хүйтэн, өдөртөө 1 градус хүйтнээс 4 градус дулаан, 2 дугаар 10 хоногийн эхээр ба сарын хуучийн эцсээр дулаарч шөндөө 1 градус хүйтнээс 4 градус, өдөртөө

## ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЖИГД АЖИЛЛАГАА

V таван жилийн төлөвлөгөөг биелүүлэх найдвартай үндсийг бүрэлдүүлэх 1974 оны төлөвлөгөөг тоо, чанарын үзүүлэлтээр ханган биелүүлэхэд үйлдвэрлэлийн жигд ажиллагааг хангах явдал чухал юм.

Үйлдвэр аж ахуйн газрууд улсын төлөвлөгөөг сар, улирал өдөр тутам биелүүлэх нь хүмүүсийн ажлын хариуцлагыг өндөржүүлж, машин техникийн ашиглалтыг сайжруулж, үйлдвэр аж ахуйн газрын чанарын үзүүлэлтийг дээшлүүлэхэд нөлөөлнө. Аймгийн төвийн үйлдвэр, барилга, тээвэр, худалдаа, холбоо зэрэг үйлдвэр аж ахуйн газруудад 220 гаруй ажилчин сар бүрийн төлөвлөгөөг 1—44,5 хувиар тасалдуулжээ. Энэ нь үйлдвэрлэлийн жигд ажиллагааг хангахад муугаар нөлөөлж байна.

## ЗОРИЛТ ДЭВШҮҮЛЭВ

Баяндэлгэр сумын илгээлтийн эздийн зөвлөдгөөн болж сумын ХЗЭ-ийн хорооны нарийн бичгийн дарга Н. Халзанхүү илгээлтийн эздийн 1973 оны ажлын дүн, 1974 оны зорилт гэсэн илтгэл тавьж хэлэлцүүлэв.

Сүүлийн 3 жилд ерөнхий боловсролын дунд сургууль төгссөн 100 гаруй сурагч МХЗЭ-ийн илгээлтээр тус нэгдэлд ажиллаж байгааг илтгэгч тэмдэглээд ажил үйлсээрээ хамт олноо манлайлж байдаг хоньчин Ганбаатар, саальчин Базарцэцэг, Жаргал, оёдолчин Долгорсүрэн нарын 100 хувьтан олноор төрөн гарч байгааг дурдлаа. Тус зөвлөдгөөнөөс 100 ба 100 давсан хувьтны хөдөлгөөнийг өрнүүлэх төл бүрийг мал болгох, зүй бусын хорогдлыг 41 хувиар багасгах зэрэг тодорхой зорилт дэвшүүлэв.

Тус сумын залуучууд түшиглэсэн байгууллагынхаа төлөвлөгөөт зорилтыг биелүүлэхийн тулд ийнхүү лэвшүүсэн зорилтоо биелүүлэхээр шамдан ажиллаж байна.

Н. БАЯРАА

1973 онд НААҮГ-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөөг 105—139 хувиар, оёдол, хивсэн тасгууд 100—176 хувиар сар бүр биелүүлсэн байхад гутал, төмрийн тасаг, ус түгээгүүрийн хэсэг 4—5 сарын төлөвлөгөөг 7,2-21,9 хувиар тасалдуулжээ.

Ингэж жигд ажиллагааг хангахгүй жилийн эцэст довтолгож байгаа дутагдал худалдааны трест, XIII авто баазад үлэмж хэмжээтэй байна.

Иймээс төлөвлөгөөг жигд биелүүлэх календарчилсан төлөвлөгөө боловсруулж, түүндээ хүмүүсийн авсан үүрэг амлалтыг нарийн тусган ажиллах шаардлагатай байна.

Үйлдвэрлэлийн жигд ажиллагааг хангахад материал техникийн хангамж онцгой ач холбогдолтой юм.

Гэтэл НААҮГ-ын оёд-

лын тасагт ажиллаж байгаа зарим оёдолчид хайцгүй байгаа бөгөөд үйлдвэрлэн гаргасан бүтээгдэхүүнийг хурдан борлуулахгүй, үйлдвэрлэснээр санаа амарч суудаг дутагдал Ойн аж ахуйн үйлдвэрт үзэгдэж байна.

Жигд ажиллагаанд нөлөөлөх гол зүйлийн нэг нь хүмүүсийн ажлын цаг ашиглалт юм.

Хотын худалдааны трестын харьяа төв дэлгүүрт ажиллаж байгаа худалдагчид ажлын цагаар үйлчилгээгээ орхих, цагийн өмнө хаах зэргээр цагийн гарздал ихээр гаргажээ.

Энэ байдлуудад дүгнэлт хийж намын эдийн засгийн бодлогыг биелүүлэхэд үйлдвэрлэлийн жигд ажиллагааг оны эхнээс хангахаа үйлдвэр аж ахуйн газрууд анхаарч ажиллавал зохино.

Р. БАЯРСАЙХАН

## ХАГАЛГААНЫ ГҮНГ ТОХИРУУЛЬЯ

Хөрснийг хагалж боловсруулах нь хаа ч гэсэн нэг үндсэн зорилготой.

Гэвч газар бүрийн хөрс цаг уурын онцлог байдлаар нь хөрсний хагалах, боловсруулах хугацаа харицан адилгүй байна.

Хагалгааны гүнг хэдий хэмжээтэй байх нь тухайн байгаль цаг уур, хөрсний бүтэцийн онцлогтой холбоотой.

Зарим хөнгөн хөртэй талбай хэдийчинээ гүн хагалсан ч төдийчинээ чийгээ алдсан байдаг нь хагалгааны гүнгийг яаж тохируулахыг шаардаж байгаа хэрэг.

Манайд 22 см гүн хагалсан байвал агро-техникийн шаардлага хангасан мэтээр үздэг нь зарим аж ахуйн удирдлагын хэвшмэл ойлгоц болжээ. Хөрсний хагалгааны гүн нь хэдий хэмжээтэй байх нь тэдгээр аж ахуйн хөрс цаг уурын онцлог байдалд ялангуяа хур тунадас унадаг хэмжээ, хөрсний ялзмагт үеийн зузаантай харьцангуйгаар хөрсний бүтэцтэй уял-

даатай тогтоогдсон байх ёстой.

Хөрсний ялзмагт үеийн хэмжээнээс гүн хагалбал түүний үржил шимийг сайжруулж чадахгүй харин ургамал ургах нөхцөлийг бүрэн хааж «Юугаар ч солж болшгүй» үнэт хөрсөө сүйтгэхэд хүрнэ.

Зарим аж ахуйд нилээд хэмжээний тариалангийн талбай атаршуулан хаясан нь үүнтэй холбоотой юм. Хөрсний хагалгааны гүнгийг тухайн аж ахуй тус бүрийн нөхцөлд тохируулах нь хөрсний хөмрүүлэгчтэй анжаар давтан хагалж байгаа нөхцөлд чухал ач холбогдолтой юм.

Аж ахуй бүр талбай тус бүртээ тохирсон хагалгааны гүнгийг тогтоож тэр хэмжээгээ аж ахуйд мөрдлөг болгоовол зохино. Энэ хэмжээг тогтооход нилээд хэдэн жилийн ажиллалт судалгаа тэдгээр талбайг хур тунадас их бага унасан нөхцөлд хэдэн янзын гүнтэйгээр хагалж туршсан туршлага шийдвэрлэнэ.

Агрономч П. ХҮРЦЭЛЭГ

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д.ТОВУУ